

**“МОНГОЛСАТ НЭТВОРКС” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /РАО/**

Энэхүү баримт бичгээр Телевизийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах Холболтын гэрээний нөхцөлийг тодорхойлсон ба Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дах хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

**“МОНГОЛСАТ НЭТВОРКС” ХХК** нь олон суваг дамжуулах үйлчилгээг **13300004** тоот тусгай зөвшөөрөлтэйгээр Монгол улсын нутаг дэвсгэрт хүргэдэг.

**1. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТ, ГОРИМ, НӨХЦӨЛ  
ШААРДЛАГА**

Телевизийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

<b>1.1 ИНТЕРФЕЙС</b>	
Дүрсийн оролт (PAL)	SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.
	HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
<b>1.2 ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>	
Дэлгэцийн харьцаа	4:3, 16:9
SD нягтрал /пикселийн тоо/	SD-SDI 625@50i
HD нягтрал /пикселийн тоо/	HD-SDI, 1080@50i
<b>1.3 ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ</b>	
Дууны түвшин	Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, эгшин зуурын утга нь $\pm 1$ байна.  XX3X-ны EBU-128 зөвлөмжийг баримтална.
Дууны кодлол	Стерео, MPEG-1 layer 2

**2. Тоног төхөөрөмжийн мэдээлэл:**

Төхөөрөмж	Загвар	Тоо	Хариуцагч	Тайлбар
SDI to IP Encoder	Dexing NDS3211	1	ТВ суваг	ТВ сувагтай IP урсгалаар холбогдох үед ашиглагдана
SDI optic transmitter	Cybervision	1	ТВ суваг	ТВ сувагтай шилэн кабелиар холбогдох үед ашиглагдана

SDI optic Receiver	Cybervision	1	Дамжуулагч	ТВ сувагтай шилэн кабелиар холбогдох үед ашиглагдана
Fiber to Ethernet Converter	CTC Union	1	ТВ суваг	ТВ сувагтай IP урсгалаар холбогдох үед ашиглагдана
Fiber to Ethernet Converter	CTC Union	1	Дамжуулагч	ТВ сувагтай IP урсгалаар холбогдох үед ашиглагдана


### 3. ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	Тайлбар, нэмэлт мэдээлэл
Байршил 1: ТВ сувгийн байр	Студийн байр
Байршил 2: Монголсат нэтворкс ХХК-н төхөөрөмжийн өрөө	СХД, 1-р хороо, Орбитын зам, Мэдээлэл холбооны сүлжээ компани, Сансрын холбооны Наран төв, Интелсатын өрөө.
Байршил 4: Орон нутагт Холбооны байр	Аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ компанийн байр


### 4. ХОЛБОЛТЫН ТӨРӨЛ

#### 4.1 Телевизийн студийн байранд холболт хийх (Байршил 1)


##### 4.1.1 SDI интерфэйсээр холболт хийх зураглал




##### 4.1.2 IP урсгалаар холболт хийх зураглал



#### 4.2 Монголсат Нэтворкс ХХК-н төхөөрөмжийн өрөөнд холболт хийх (Байршил 2)



4.3 Орон нутгийн телевизийн холболт хийх зураглал (Байршил 3)



## 5. ГЭРЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ

### Нэг: Хөтөлбөр дамжуулах явцын мэдээлэл солилцох тухай

- 1.1 Хөтөлбөрийг чанарын өндөр түвшинд дамжуулахын тулд талууд хамтран ажиллаж, харилцан мэдээллээр хангагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 1.2 Хөтөлбөрийг чанарыг Талууд байнга хянаж, гарсан доголдол саатал болон техник тоног төхөөрөмжийн ажиллагааны талаар дүгнэлт өгч мэдээлэл солилцож гарсан доголдол саатлын шалтгааныг үнэн зөв тодорхойлж тэмдэглэл хийсэн байна. /Хүснэгт 1/
- 1.3 Хөтөлбөрийг чанарын мэдээг шаардлагатай тохиолдолд гаргаж зохих дүгнэлтийг өгч ажиллана. /Хүснэгт 2/
- 1.4 Мэдээ гаргах нэгдсэн нэг загварын маягтыг мөрдлөг болгон хөтөлнө.
- 1.5 Мэдээлэл солилцох хаяг утас болон дамжилтын трактын схемийг нэгтгэн гаргаж ажлын байранд байрлуулсан байна.
- 1.6 Талууд өөрсдийн хариуцсан тоног төхөөрөмж, дамжилтын схемийг нарийвчлан гаргаж энэ талаар харилцан мэдээлэлтэй байна

Хүснэгт 1

Сар өдөр	Хөтөлбөрийн нэр ба чиглэл	Гарсан саатал ба доголдол				Ажилласан инженер		Засварласан тухай тэмдэглэл
		эхэлсэн	дууссан	Нийт хугацаа	шалтгаан	Газрын станцад	ТВ-студид	

Хугацаа	Гарсан доголдол саатлын шинж					Гарсан хохиролын хэмжээ	Тохиролцон тухай тэмдэглэл
	Хүний буруутай ажиллагаанаас	Техникийн саатлаас	Цаг агаарын нөхцөлөөс	Гаднын байгууллагын буруутай ажиллагаанаас	Цахилгааны саатлаас		

### Хоёр. Талуудын харилцан холбоо барих мэргэжилтнүүдийн мэдээлэл

#### “МОНГОЛСАТ НЕТВОРКС” ХХК-ний зүгээс:

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>DTN ашиглалтын ахлах инженер Б.Бямбанайдан Утас: 99067608. byambanaidan@mongolsat.mn</i>
2.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>Санхүүгийн албаны захирал Ч.Доржпагам Утас: 99948945. dorjpagam@mongolsat.mn</i>
3.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>Маркетингийн захирал А.Ариунаа Утас: 88118446. ariunaa@mongolsat.mn</i>
4.	Гэрээ болон контентын асуудал гарсан үед:	<i>Ерөнхий менежер М.Оюунцэцэг Утас: 9908 1038. info@mongolsat.mn</i>

#### ТВ сувгийн зүгээс:

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....</i>
2.	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:	<i>Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....</i>
3.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....</i>
4.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:	<i>Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....</i>

#### Тайлбар:

Гэмтэл, сааталтай холбоотой тусгай журамлал: Аль нэг талд техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл талуудын инженерүүд бие биетэйгээ түргэн, шуурхай холбогдож, хамтран ажиллаж, тухайн асуудлыг шийдвэрлэхийг эрхэмлэнэ. ТВ сувгийн зүгээс техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсны улмаас цацалт доголдож улмаар хэрэглэгч, үзэгчдийн зүгээс гомдол, санал гаргах, цацалтын үйлчилгээ, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа нөхцөл байдал олон нийт, нийгмийн сэтгэл зүйд үүсэх, эсхүл ийм нөхцөл байдал хэдийн үүссэн байдаг тул ТВ сувгийн зүгээс дээрх хүснэгтэд нэр дурдсан эсэхээс үл хамааран тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага зэрэгтэй холбоо барин шаардлагатай

инженер, техникийн ажилтантай холбож өгөх талаар санал болгох эрхтэй. Тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага нь энэхүү санал, хүсэлтийг хүлээн авч, найрсаг, түргэн шуурхайгаар зохицуулж өгөх арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

## 6. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТӨЛБӨР ТООЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

### 1. Сар бүрийн суваг дамжуулалтын төлбөр

№	Зардлын нэр төрөл	Холболтын төрөл	Суваг дамжуулалтын төлбөр ₮	
			УБ хот	Орон нутаг
1	1 Mbps IP урсгал түрээс	IP	....₮	....₮
2	Шилэн кабелийн түрээс	SDI	....₮	....₮

Жич: Дээрх бүх төлбөрт НӨАТ ороогүй болно.

Тайлбар:

- “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.9-д зааснаар дээрх төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй байх зарчмыг баримтална.
- SD сувгийн хувьд хамгийн багадаа 2Mbps, HD сувгийн хувьд хамгийн багадаа 4Mbps урсгал шаардлагатай.
- Сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг нь Монголсат Нэтворкс ХХК-н төхөөрөмжийн өрөөнд бол шилэн кабелийн болон урсгал түрээсийн төлбөр 0₮ байна.

## 7. ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

### МОНГОЛСАТ НЭТВОРКС ХХК БОЛОН \_\_\_\_\_-ИЙН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

20.... оны ....-р сарын .... өдөр № ...../...../.....

Улаанбаатар хот

Нэг талаас Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-4, Экспресс тауэр 203 тоот хаягт байрлах, регистрийн 2590999 дугаартай МОНГОЛСАТ НЭТВОРКС ХХК /цаашид “Дамжуулагч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Бумчин

Нөгөө талаас ..... хаягт байрлах, регистрийн ..... дугаартай ..... ХХК /цаашид “ТВ суваг” гэх/ түүнийг төлөөлж ..... нар /хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх/

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооны (цаашид ХХЗХ гэх) холбогдох журам, нөхцөл шаардлагуудыг тус тус удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Дамжуулагч нь ТВ сувгийн “\_\_\_\_\_” нэр лого бүхий сувгийг \_ дугаарлалт дээр Монгол орны нутаг дэвсгэрт хиймэл дагуулын сүлжээ ашиглан дамжуулах болон ОТТ буюу интернэтэд суурилсан телевизийн Олон сувгийн үйлчилгээгээрээ хэрэглэгчдэд хүргэхээс гадна дамжуулах үйлчилгээг тасралтгүй, хэвийн найдвартай явуулах, ТВ суваг нь холболт хийхэд шаардагдах тоног төхөөрөмж

болон холболтын урсгал зардлыг Дамжуулагчид төлөхтэй холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү гэрээ нь Талуудын төлөөлөл, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байна.

1.3 Талууд холболт хийхдээ ижил төстэй бусад гэрээлэгч байгууллагууддаа ямар нэгэн ялгаваргүй, ижил нөхцлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.

## ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 Энэхүү гэрээнд заасан нэр томъёонуудыг дор дурьдсан утгаар ойлгоно:
- 2.1.1 “ХХЗХ” гэж Харилцаа холбооны зохицуулах хороог;
  - 2.1.2 “Хөтөлбөр” гэж бүх төрлийн нэвтрүүлгийг радио, телевизээр дамжуулах хуваарьт оруулсан багцыг;
  - 2.1.3 “Суваг” гэж радио, телевизийн хөтөлбөрийг дамжуулах сүлжээний багтаамжийн нэгжийг;
  - 2.1.4 “Хэрэглэгч” гэж Дамжуулагчийн эцсийн хэрэглэгчийг;
  - 2.1.5 “Сувгийн дугаар” гэж Дамжуулагчийн сүлжээгээр дамжуулах сувгийн дугаарлалтыг.

## ГУРАВ. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХОЛБОЛТ ХИЙХ НӨХЦӨЛ

- 3.1 Дамжуулагч нь ТВ сувгаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ТВ сувгийн хөтөлбөрийг өөрийн хиймэл дагуулын сүлжээнд холбох ба холболтын зардлыг ТВ суваг хариуцна.
- 3.2 ТВ суваг нь дараах нөхцөлийг биелүүлнэ. Үүнд:
- 3.2.1 Дамжуулагчийн сүлжээнд холбогдох хүсэлтийг албан бичгээр ирүүлнэ.
  - 3.2.2 Аж ахуйн нэгжийн гэрчилгээ, түүнд тусгагдсан иргэний үнэмлэхийн хуулбаруудыг ирүүлнэ.
  - 3.2.3 Телевизийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн эрхийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.  
Сувгийн нэр: .....  
Хамрах хүрээ: .....
  - 3.2.4 Тус гэрээний хавсралт №1-с дамжуулагчийн сүлжээнд холбогдох холболтын төрөл болон эцсийн хэрэглэгчид хүрэх дүрсийн нягтралыг сонгоно.  
Холболтын төрөл /доогуур зурах/: SDI холболт, IP холболт  
Дүрсийн нягтрал /доогуур зурах/: SD, HD
- 3.3 Дамжуулагч нь дараах нөхцөлийг биелүүлнэ. Үүнд:
- 3.3.1 ТВ сувгаас ирүүлсэн албан хүсэлтэд ажлын 10 хоногийн дотор хариу өгнө.
  - 3.3.2 Өөрийн сүлжээгээр дамжуулах сувгийн дугаарлалтыг олгоно.  
Сувгийн дугаар: .....  
жич: Сувгийн дугаарыг ТВ сувагт өмчлүүлэхгүй.
- 3.4 Талууд холболт хийхдээ ХХЗХ-оос баталсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 3.5 Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудтай байх ба хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг байна.  
Хавсралт №1: ТЕХНИК ТӨХӨӨРӨМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗААГЛАХ ЦЭГ, ХОЛБОЛТЫН ЗУРАГЛАЛ  
Хавсралт №2: ХӨТӨЛБӨР ДАМЖУУЛАХ ЧАНАРЫН ТУХАЙ  
Хавсралт №3: ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ТУХАЙ  
Хавсралт №4: ТӨЛБӨР ТООЦООНЫ ТУХАЙ

Хавсралт №5: ХӨТӨЛБӨР ИЛГЭЭХ ТУХАЙ  
**ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

- 4.1 Гэрээ нь 20..... оны ..... сарын .....-ний өдрөөс 20..... оны ..... сарын .....-ний өдөр хүртэл ..... жилийн хугацаатай байна.
- 4.2 Гэрээний хугацаа дуусахад Талууд Гэрээг цуцлах санал гаргаагүй бол Гэрээг анх байгуулсан нөхцөл хугацаагаар сунгагдсанд тооцно.

**ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО**

- 5.1 ТВ суваг нь холболтын зардлыг тооцохдоо хавсралт №1-с сонгосон холболтын төрөл болон дүрсний нягтралаас хамаарч энэхүү гэрээний Хавсралт №4-г баримтална.
- 5.2 Талууд харилцан тохиролцож шилэн кабелийн эсвэл урсгал түрээсийн төлбөрийн хэмжээг хавсралт №4-д тусгайлан тогтооно.
- 5.3 ТВ суваг нь энэхүү гэрээний Хавсралт №4-д заасан нэг удаагийн төлбөрийг Дамжуулагчийн нэхэмжлэхийн дагуу гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор, харин сар тутмын төлбөрийг Хавсралт №4-д заасан сар тутмын төлбөрийг дамжуулагчийн нэхэмжлэхийн дагуу тухайн сардаа багтаан Дамжуулагчийн Төрийн банкны **109000126176** тоот дансанд шилжүүлнэ.
- 5.4 ТВ суваг нь хөтөлбөрөө HD форматаар эцсийн хэрэглэгчид дамжуулах тохиолдолд Хавсралт №4 дэх нэмэлтээр нэг удаагийн болон сар тутмын төлбөрийг Дамжуулагчийн нэхэмжлэхийн дагуу тухайн сардаа багтаан Дамжуулагчийн Төрийн банкны **109000126176** тоот дансанд шилжүүлнэ.
- 5.5 ТВ суваг нь газар зүйн байршлаа сольсон тохиолдолд шилэн кабель татах болон түүнтэй холбогдон гарах бүх зардлыг 100% хариуцна.
- 5.6 Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь сар бүр тооцоо нийлэн ажиллах бөгөөд Тооцоо нийлэх санхүүгийн ажилтны мэдээллийг Хавсралт №3-д оруулсан байна.
- 5.7 Талууд төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож, нөгөө талдаа алданги төлнө.
- 5.8 Талуудын ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.

**ЗУРГАА. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 6.1 Дамжуулагч нь дараах эрхтэй. Үүнд:
- 6.1.1 ТВ сувгийг гэрээнд заасан төлбөрийг хугацаандаа төлөхийг шаардах;
- 6.1.2 ТВ сувгаас хамаарсан гэмтэл, саатлын улмаас эфирийг тасалдуулсан тохиолдолд Дамжуулагч нь энэ талаар хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх;
- 6.1.3 ТВ суваг нь Дамжуулагчийн албан ёсны эрхтэй аливаа контентийг зөвшөөрөлгүйгээр Сувгаар гаргахгүй байхыг шаардах, гаргасан нөхцөлд холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх;
- 6.1.4 Дамжуулагч нь техник, технологио шинэчлэх, өргөтгөх, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой ажлыг ТВ сувагт урьдчилан бичгээр эсвэл мэйлээр мэдэгдсэний үндсэн дээр гүйцэтгэх;
- 6.1.5 ТВ сувгийн буруутай үйл ажиллагааны улмаас эсхүл Гэрээнд заасан дамжуулалтын зардлыг төлөөгүйн улмаас Дамжуулагчид хохирол учирсан тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлэх;
- 6.1.6 Байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, халдварт өвчин гарах, онц ноцтой гал түймэр дэгдэх, дайны болон онц байдал зарлах, зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсоны улмаас эрх бүхий байгууллагын үүрэг болгосны дагуу ТВ сувгийн ямар ч нэвтрүүлгийн дундуур тухайн байдлын талаар олон нийтэд мэдээлэл хийх;
- 6.1.7 Холбогдох хуульд заасан бусад эрх;

- 6.2 Дамжуулагч нь дараах үүрэгтэй. Үүнд:
- 6.2.1 Дамжуулагч нь Сувгийг техникийн доголдолгүй дамжуулах;
  - 6.2.2 Өөрийн хиймэл дагуулын сүлжээгээр Суваг дамжуулах үйлчилгээг гэрээний хугацаанд чанартай, тогтвортой явуулж, Сувгийг өөрийн багцуудад оруулан Хэрэглэгчдэд дамжуулах;
  - 6.2.3 Дамжуулагч нь өөрийн хэрэглэгчийн эрх ашигийг бүрэн хангаж, Сувгийг ямар ч нөхцөлд хариуцлагатай, алдаагүй, шууд, хөндлөнгийн нөлөөлөлд авталгүй дамжуулах;
- 6.3 ТВ суваг нь дараах эрхтэй. Үүнд:
- 6.3.1 Дамжуулагчийн үзүүлж буй үйлчилгээ болон хийгдэж буй ажлууд нь чанарын шаардлага хангахгүй гэж үзвэл санал гаргах, шаардлага тавих;
  - 6.3.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсхүл зохих ёсоор буюу шударгаар биелүүлэхийг Дамжуулагчаас шаардах;
  - 6.3.3 Гэрээнд заасан нөхцөлийн дагуу Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах тухай санал гаргах;
  - 6.3.4 Дамжуулагчийн буруутай үйлдлийн улмаас өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах ба энэ тохиолдолд Дамжуулагч буруутай болох нь эрх бүхий этгээдээр тогтоогдсон байх;
  - 6.3.5 Гэрээний явцад харилцан хяналт тавих, зөрчил дутагдлыг хугацаа тогтоон засахыг шаардах;
  - 6.3.6 Хуульд заасан бусад эрх;
- 6.4 ТВ суваг нь дараах үүрэгтэй. Үүнд:
- 6.4.1 Хөтөлбөрийн дуу дүрсний дохиог Дамжуулагчийн шаардсан техникийн нөхцөл Хавсралт №1-ийг дагаж мөрдөж, Хавсралт №1-т заасан “Зааглах цэг”-т өөрийн Сувгийг авчирсан байх;
  - 6.4.2 Дамжуулагчаас өгсөн техникийн нөхцөл, шаардлагыг хангах техник тоног төхөөрөмжтэй байх, тэдгээрийн ашиглалт үйлчилгээ хэвийн найдвартай ажиллагааг гэрээний хугацаанд тогтвортой хангаж ажиллах;
  - 6.4.3 Сувгийг холбогдох хууль, журам, нөхцөл шаардлагад зааснаас бусад нөхцөлд түр хаахгүй;
  - 6.4.4 ТВ суваг өөрийн хөтөлбөр, контент нь хууль зөрчиж буй эсэх, оюуны өмчийн зөрчилтэй эсэхэд хяналт тавих, түүнээс үүдэлтэй аливаа маргаанд бие даан хариуцлага хүлээх;
  - 6.4.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл, лицензийг зохих журмын дагуу цаг тухайд нь эрх бүхий байгууллагаас авч, хүчин төгөлдөр байдлыг нь гэрээний хугацаанд хэвээр хадгалах;
  - 6.4.6 Гэрээнд заасан төлбөрийг гэрээнд заасан хугацаанд нэхэмжлэхийн дагуу Дамжуулагчид төлж байх;
  - 6.4.7 Дамжуулагчийн албан ёсны эрхтэй аливаа контентийг зөвшөөрөлгүйгээр өөрийн Сувгаар гаргахгүй байх;
  - 6.4.8 Олон суваг дамжуулах тусгай зөвшөөрөлгүй аливаа аж ахуйн нэгжтэй холболт хийхгүй байх;
  - 6.4.9 Дамжуулагчаас хамааралгүйгээр аливаа техникийн саатал гарсны улмаас Суваг гарахгүй болсон тохиолдолд ТВ суваг нь “МАНАЙ СУВГИЙН ТЕХНИКТЭЙ ХОЛБООТОЙ ЭФИРИЙН СААТАЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ” гэсэн утга, агуулгатай мэдэгдлийг өөрийн сувгийн дэлгэц дээр байршуулах;
  - 6.4.10 Тоног төхөөрөмжтэй холбоотой өөрчлөлт, түр зогсолт, техникийн шинэчлэл хийгдэх, байршил солих гэх мэт зорилгоор эфирээ таслах буюу зайлшгүй зогсолт хийх тохиолдолд 7 хоногийн өмнө Дамжуулагч талд бичгээр болон имэйлээр урьдчилан мэдэгдэх;

## **ДОЛОО. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ЗААГЛАХ ЦЭГ**

- 7.1 Холболт хийх техникийн нөхцөл:



- 7.1.1 Холболт хийхэд шаардагдах техник төхөөрөмж, түүнд тавигдах шаардлага, стандарт үзүүлэлт зэрэг нь **Хавсралт №1**-ийн дагуу байна. **Хавсралт №1**-д өөрчлөлт орсон тохиолдол бүрд шинэчлэн, батлан, гэрээнд шинээр хавсаргана.
  - 7.1.2 ТВ сувгийн студиас ирэх дохио нь Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хангасан байна.
  - 7.1.3 Талуудын сүлжээ хооронд холболт хийх дамжуулах шугам нь өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ эсвэл түүний IP урсгал байна.
- 7.2 Зааглах цэг:
- 7.2.1 Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.
  - 7.2.2 Сүлжээний зааглах цэгийн байршил, холболтын зураглал нь Хавсралт №1-т заасны дагуу байна.
  - 7.2.3 Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

### **НАЙМ. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 8.1 Зааглах цэгээс 2 тийш Талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ буюу бүрэн бүтэн байдал, тасалдалгүй найдвартай ажиллагаа, чанарын хяналт, гэмтэл засварыг хариуцна.
- 8.2 Дамжуулагч өөрийн сүлжээнд энэхүү гэрээгээр зохицуулж байгаа холболтод хамаарах аливаа туршилт, техникийн шинэчлэл, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд ажиллах хугацаа, горимыг хуанлийн 1 хоногийн өмнө урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 8.3 Талууд дур мэдэн ганцаар шийдвэр гарган, нөгөө талынхаа үйлчилгээг таслах эрхгүй бөгөөд, хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан Тал нь шуурхай арга хэмжээ авч, нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх ба нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар Талуудын техникийн ажилтнууд тодорхой тэмдэглэл хөтөлж, удирдлагаар баталгаажуулан тайлагнан, хадгална.
- 8.4 Аль нэг Талын буруутай үйлдлээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах тохиолдолд буруутай этгээд нь нөгөө Тал болон хэрэглэгчийг хохироохгүй байх бүхий л арга хэмжээг авна.
- 8.5 Техникийн гэмтэл, саатал, үзлэг үйлчилгээний үед Дамжуулагч нь Сувгаар дараах мэдэгдэл бүхий текстийг дамжуулна.
  - 8.5.1 Дамжуулагч талд техникийн гэмтэл, саатал гарсан бол “**ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭНД ГЭМТЭЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ**”;
  - 8.5.2 ТВ суваг талд гэмтэл, саатал гарсан бол “**ТЕЛЕВИЗЭД ТЕХНИКИЙН ГЭМТЭЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ**”;
  - 8.5.3 Хуваарьт үзлэг, үйлчилгээ хийж байгаа бол “**ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ХИЙЖ БАЙНА**” боломжтой бол хэвийн үргэлжлэх хугацааг дурдах;
- 8.6 Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг Хавсралт №3-д заасан байна.

### **ЕС. ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ**

- 9.1 ТВ суваг нь долоо хоног бүрийн Баасан гаригийн **15:00** цагаас өмнө Сувгийн хөтөлбөрийг \_\_\_\_\_@\_\_\_\_\_ и-мэйл хаягаас дамжуулагч талын **programme@mongosat.mn** и-мэйл хаяг руу илгээнэ.
- 9.2 ТВ суваг нь хөтөлбөрөө Хавсралт №5-д заасан форматын дагуу бэлтгэн илгээнэ.
- 9.3 Хөтөлбөрт өөрчлөлт оруулах бол 9.1-д заасан хаяг руу хөтөлбөр өөрчлөгдөх өдрөөс ажлын 1 өдрийн өмнө ажлын цагаар илгээнэ.
- 9.4 Дамжуулагч талд урьдчилан илгээлгүйгээр хөтөлбөрт оруулсан өөрчлөлт, хөтөлбөрийн зөрүүтэй байдлаас үүссэн гомдол, маргааныг Дамжуулагч тал хариуцахгүй.

- 9.5 Хөтөлбөрөөс бусад гэрээтэй холбоотой харилцааг албан бичгээр болон Хавсралт №3-т тодорхойлсон хариуцсан этгээд рүү цахим шуудангаар илгээж үйлдэнэ.
- 9.6 Талууд ирсэн хүсэлт, шаардлага, мэдэгдэлд цахим шуудангаар өдөртөө, албан бичгээр ажлын 5 өдөр дотор хариулна.
- 9.7 Талууд гэрээний ажлыг хэвийн, чанартай, тасралтгүй явуулахын тулд шаардлагатай мэдээллүүдийг тогтмол солилцох бөгөөд солилцож буй мэдээллийн нууцлалыг хамгаална.

### **АРАВ. ОЮУНЫ ӨМЧИЙН ХАРИЛЦАА**

- 10.1 Дамжуулагч нь ТВ сувгийн албан ёсны логог дамжуулахдаа түүний хэлбэр дүрс, өнгө зэрэгт ямар нэг байдлаар өөрчлөлт оруулалгүйгээр дамжуулна.
- 10.2 ТВ суваг нь өөрийн албан ёсны логог Дамжуулагчийн **info@mongolsat.mn** хаягаар цахим хэлбэрээр өгнө.
- 10.3 Талууд хөтөлбөр бэлтгэх, хүргэх үйл ажиллагаандаа оюуны өмчийг дээдэлж, оюуны өмчийн зөрчилтэй Талууд хамтран тэмцэнэ.
- 10.4 ТВ сувгийн албан ёсны логог Дамжуулагч нь өөрийн үндсэн үйлчилгээний танилцуулга сурталчилгаа, тараах материалд ашиглах бөгөөд телевизийн логоны хэлбэр дүрс, өнгө зэрэгт ямар нэг байдлаар өөрчлөлт оруулахгүйгээр ашиглана.

### **АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА**

- 11.1 Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талд хохирол учирсан бол хохирсон тал өөрийн хохирлын хэмжээг нотлох үүрэгтэй бөгөөд буруутай тал нь нөгөө талд учирсан хохирлыг Гэрээнд болон хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлнө.
- 11.2 ТВ суваг нь Дамжуулагчийн тоног төхөөрөмжөөр дамжин хэрэглэгчдэд очиж байгаа Сувгийн чанар, стандартад хяналт тавих, зохиогчийн эрхээр хамгаалагдсан телевизийн нэвтрүүлэг, дуу, дүрс, кино зэргийг зохих зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлсэнтэй холбоотой хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 11.3 Байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, халдварт өвчин гарах, онц ноцтой гал түймэр дэгдэх, дайны болон онц байдал зарлах, зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ бүгдийг, эсхүл аль нэгийг нь биелүүлээгүй бол ийнхүү биелүүлээгүйн улмаас гарах үр дагаварт талууд хариуцлага хүлээхгүй.
- 11.4 Дамжуулагч нь ТВ Сувгаар цацагдаж буй мэдээ, мэдээлэл болон контент-д ямарваа нэгэн хариуцлага хүлээхгүй.
- 11.5 Дамжуулагч нь Сувгийг Хэрэглэгчид зориулан дамжуулах үүрэгтэй бөгөөд контент хянах, хөтөлбөр нягтлах, хөтөлбөртэй хамааралтай аливаа хариуцлага хүлээхгүй.
- 11.6 Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх, эсхүл удаа дараа биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг хангах дор дурдсан аргыг шат дараатайгаар хэрэглэнэ. Үүнд:
  - 11.6.1 гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар мэдэгдэл хүргүүлэх;
  - 11.6.2 энэхүү гэрээний 5.7-д зааснаар алданги, торгууль тооцох;
  - 11.6.3 аль нэг тал нь төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн тохиолдолд хязгаарлалт, салгалтыг хийж, төлбөрийг шийдвэрлэх дараагийн шатны арга хэмжээ рүү шилжих;
- 11.7 Энэхүү гэрээний 11.6-д заасан арга хэмжээг хүлээсэн нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх хууль зүйн үндэслэл болохгүй.

### **АРВАН ХОЁР. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 12.1 Гэрээний үүргийн биелэлттэй холбогдон үүссэн аливаа маргааныг нөгөө талдаа албан хүсэлт тавих зарчимаар зөвшилцөн шийдвэрлэнэ.

- 12.2 Талууд маргаанаа зөвшилцлөөр шийдвэрлэж чадаагүй нөхцөлд ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 12.3 ХХЗХ-оос гаргасан шийдвэрийг маргалдагч Талууд хүлээж авна. Хэрэв тус хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Талууд шүүхэд хандах эрхтэй.

### **АРВАН ГУРАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ЦУЦЛАХ**

- 13.1 Гэрээнд заасан үүргийг Талууд зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл хуулийн этгээд эрх залгамжлалгүйгээр татан буугдсан, улсын бүртгэлээс хасагдсан зэрэг тохиолдолд гэрээ шууд дуусгавар болно.
- 13.2 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй эсвэл удаа дараа биелүүлээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардсан албан бичиг хүргүүлэх бөгөөд хүргүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор тухайн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талдаа гэрээг цуцлах тухай санал гаргаж болох ба уг саналыг бичгээр гаргана.
- 13.3 Гэрээ цуцлах санал гаргаснаас ажлын 10 хоногийн дотор нөгөө талаас ямар нэг хариу өгөөгүй тохиолдолд гэрээ цуцлагдсанд тооцно.
- 13.4 Талууд харилцан хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гэрээг цуцалж болно.
- 13.5 Энэхүү гэрээг цуцалсантай холбоотойгоор талуудын өглөг авлагын төлбөр тооцоог буруутай тал нь төлж барагдуулна.

### **АРВАН ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ**

- 14.1 Гэрээг хоёр хувь үйлдэж баталгаажуулах бөгөөд хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.
- 14.2 Гэрээний хэрэгжилттэй уялдуулан талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд түүнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна.
- 14.3 Гэрээний хавсралт болон нэмэлтээр талуудын тохиролцсоны дагуу бусад зүйлийг нарийвчлан тодорхойлж, бусад нөхцөлийг тусгаж өгнө.
- 14.4 Талууд шүүх болон бусад эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд энэхүү гэрээ болон түүнтэй холбогдох бичиг баримтын нууцлалыг чандлан хадгална.
- 14.5 Монгол Улсад бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хөл хорио тогтоосонтой холбогдуулан Талууд Иргэний хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т заасан нөхцөлийн дагуу энэхүү Гэрээнд заасан нөхцөлийг зөвшөөрсөн хариуг электрон шуудангаар ирүүлснээр энэхүү Гэрээг байгуулсанд тооцож, хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөр талууд тохиролцов. Энэ тохиолдолд ТВ сувгийн Гүйцэтгэх захирал \_\_\_\_\_ -ын .....@.....com, хаягаар ирүүлсэн хариуг албан ёсны хариу гэж үзнэ.

### **ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН МЭДЭЭЛЭЛ:**

**МОНГОЛСАТ НЭТВОРКС ХХК**

**Хаяг:**

\_\_\_\_\_ **ХХК** \_\_\_\_\_ **ТВ**

Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн

чөлөө-4, Экспресс тауэр 203 тоот

**Бүртгэлийн гэрчилгээ:** 9011757040

**Регистрийн дугаар:** 2590999

**Оффисын утасны дугаар:** 71000011

**Цахим хаяг:** info@mongolsat.mn

**Гүйцэтгэх захирал:** Н.Бумчин

\_\_\_\_\_ /гарын үсэг/

**Гар утасны дугаар:** 99081038

**Цахим хаяг:** info@mongolsat.mn

Бүртгэлийн гэрчилгээ: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Оффисын утасны дугаар: \_\_\_\_\_

Цахим хаяг: \_\_\_\_\_

Гүйцэтгэх захирал:

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: \_\_\_\_\_

Цахим хаяг: \_\_\_\_\_

..../..../.... тоот гэрээний Хавсралт №1

## ТЕХНИК ТӨХӨӨРӨМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗААГЛАХ ЦЭГ, ХОЛБОЛТЫН ТӨРӨЛ

### 8. ТВ сувгийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

1.1 ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт (PAL)	SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.
	HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
1.2 ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дэлгэцийн харьцаа	4:3, 16:9
SD нягтрал /пикселийн тоо/	SD-SDI 625@50i
HD нягтрал /пикселийн тоо/	HD-SDI, 1080@50i
1.3 ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, эгшин зуурын утга нь $\pm 1$ байна. XX3X-ны EBU-128 зөвлөмжийг баримтална.

Дууны кодлол	Стерео, MPEG-1 layer 2
--------------	------------------------

### 9. Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

Төхөөрөмж	Загвар	Тоо	Хариуцагч	Тайлбар
SDI to IP Encoder	Dexing NDS3211	1	ТВ суваг	ТВ сувагтай IP урсгалаар холбогдох үед ашиглагдана
SDI optic transmitter	Cybervision	1	ТВ суваг	ТВ сувагтай шилэн кабелиар холбогдох үед ашиглагдана
SDI optic Receiver	Cybervision	1	Дамжуулагч	ТВ сувагтай шилэн кабелиар холбогдох үед ашиглагдана
Fiber to Ethernet Converter	CTC Union	1	ТВ суваг	ТВ сувагтай IP урсгалаар холбогдох үед ашиглагдана
Fiber to Ethernet Converter	CTC Union	1	Дамжуулагч	ТВ сувагтай IP урсгалаар холбогдох үед ашиглагдана


### 10. ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	Тайлбар, нэмэлт мэдээлэл
Байршил 1: ТВ сувгийн байр	Студийн байр
Байршил 2: Монголсат нэтворкс ХХК-н төхөөрөмжийн өрөө	СХД, 1-р хороо, Орбитын зам, Мэдээлэл холбооны сүлжээ компани, Сансрын холбооны Наран төв, Интелсатын өрөө.
Байршил 4: Орон нутагт Холбооны байр	Аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ компанийн байр


### 11. ХОЛБОЛТЫН ТӨРӨЛ

#### 4.1 Телевизийн студийн байранд холболт хийх (Байршил 1)


##### 11.1.1 SDI интерфэйсээр холболт хийх зураглал




##### 11.1.2 IP урсгалаар холболт хийх зураглал



11.2 Монголсат Нэтворкс ХХК-н төхөөрөмжийн өрөөнд холболт хийх (Байршил 2)



11.3 Орон нутгийн телевизийн холболт хийх зураглал (Байршил 3)



**ХАВСРАЛТЫГ БАТЛАВ:**

Гүйцэтгэх захирал: **Н.Бумчин**

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: 99081038

Цахим хаяг: info@mongolsat.mn

Технологийн газрын захирал: **Баянбаатар**

Гар утасны дугаар: 99018367

Цахим хаяг: bayanbaatar@mongolsat.mn

Гүйцэтгэх захирал:

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: \_\_\_\_\_

Цахим хаяг: \_\_\_\_\_

### ХӨТӨЛБӨР ДАМЖУУЛАХ ЧАНАРЫН ТУХАЙ

- 1.1 Дамжуулагчийн Сувгийг чанарын өндөр түвшинд дамжуулж хэрэглэгчдэд хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд энэхүү зарчим мөрдөгдөнө.
- 1.2 Сувгийн бүрэн трактын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж нэвтрүүлгийг доголдол сааталгүй дамжуулах үүргийг бүрэн трактад хамрагдан ажиллаж байгаа бүх хүн адил тэгш хүлээж, хамтран ажиллана. Сувагт тавигдах үндсэн шаардлага нь Монгол улсын MNS:5592-2 стандартад заагдсан нормыг баримтална.
- 1.3 Сувгийн доголдол саатлыг дүрсний, дууны гэж ангилан гарсан тухай бүр нь дээрх чиглэлээр цаг хугацааг тооцож, хамтран ажиллагчид харилцан шалгалт хэмжилтийг хийж богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлнэ.
- 1.4 Талуудын зааглах цэгийн байршилыг хавсралт №1-т заасан бөгөөд уг цэгээс дотогш өөрт хамаарч буй тоног төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт, үйлчилгээний найдвартай хэвийн ажиллагааг талууд бүрэн хариуцна.
- 1.5 Гэмтэл саатал гарсан тохиолдолд Талууд өөр өөрсдийн зааглах цэгээс дотогш гарсан гэмтэл саатлыг бие даан хариуцах ба ТВ суваг нь өөрийн талд үүссэн гэмтэл саатлыг Дамжуулагчаар засварлуулах хүсэлт гаргасан бол гарсан зардлыг хариуцан төлнө.
- 1.6 Эрчим хүчний найдвартай ажиллагааг Талууд өөрсдийн хариуцах талдаа хангана.
- 1.7 Сувгийн холболтын тоног төхөөрөмжид дур мэдэн өөрчлөлт оруулахгүй байх үүрэгтэй.
- 1.8 Талууд үйлчилгээний чанар нь стандарт түвшинд хэвийн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд ТВ сувгийн үйлчилгээний чанар нь стандарт түвшинд хүрэхгүй бол тухай бүр Дамжуулагч нь ТВ сувгийн ажилтанд холбогдох мэдээллийг хүргэж шуурхай арга хэмжээ авч хамтран ажиллана.
- 1.9 Талууд аливаа гэмтэл саатал гарсан үед холбогдох мэдээллийг хүргэх бөгөөд үүссэн гэмтэл сааталд шуурхай арга хэмжээ авч засварлан ажиллана.
- 1.10 Системд өөрчлөлт шинэчлэлт оруулах, Техникийн зайлшгүй шалтгааны улмаас түр хугацаанд систем дээр төлөвлөгөөт ажил хийхээр бол гэрээнд заасны дагуу мэдээллийг хүргэж ажиллана.
- 1.11 ТВ суваг нь 14 хоногоос дээш хугацаанд хөтөлбөрөө өгөөгүй тохиолдолд дамжуулагч нь сувгийг хаах ба тухайн сувгийн дугаарлалтыг хадгалах үүрэг хүлээхгүй.

### ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Гүйцэтгэх захирал: Н.Бумчин

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: 99081038

Цахим хаяг: info@mongolsat.mn

Технологийн газрын захирал: Б.Баянбаатар

Гар утасны дугаар: 99018367

Цахим хаяг: bayanbaatar@mongolsat.mn

Гүйцэтгэх захирал:

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: \_\_\_\_\_

Цахим хаяг: \_\_\_\_\_

## ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ТУХАЙ

### Нэг: Хөтөлбөр дамжуулах явцын мэдээлэл солилцох тухай

- 1.7 Хөтөлбөрийг чанарын өндөр түвшинд дамжуулахын тулд талууд хамтран ажиллаж, харилцан мэдээллээр хангагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 1.8 Хөтөлбөрийг чанарыг Талууд байнга хянаж, гарсан доголдол саатал болон техник тоног төхөөрөмжийн ажиллагааны талаар дүгнэлт өгч мэдээлэл солилцож гарсан доголдол саатлын шалтгааныг үнэн зөв тодорхойлж тэмдэглэл хийсэн байна. /Хүснэгт 1/
- 1.9 Хөтөлбөрийг чанарын мэдээг шаардлагатай тохиолдолд гаргаж зохих дүгнэлтийг өгч ажиллана. /Хүснэгт 2/
- 1.10 Мэдээ гаргах нэгдсэн нэг загварын маягыг мөрдлөг болгон хөтөлнө.
- 1.11 Мэдээлэл солилцох хаяг утас болон дамжилтын трактын схемийг нэгтгэн гаргаж ажлын байранд байрлуулсан байна.
- 1.12 Талууд өөрсдийн хариуцсан тоног төхөөрөмж, дамжилтын схемийг нарийвчлан гаргаж энэ талаар харилцан мэдээлэлтэй байна

Хүснэгт 1

Сар өдөр	Хөтөлбөрийн нэр ба чиглэл	Гарсан саатал ба доголдол				Ажилласан инженер		Засварласан тухай тэмдэглэл
		эхэлсэн	дууссан	Нийт хугацаа	шалтгаан	Газрын станцад	ТВ-студид	

Хүснэгт 2

Хугацаа	Гарсан доголдол саатлын шинж					Гарсан хохиролын хэмжээ	Тохиролцсон тухай тэмдэглэл
	Хүний буруутай ажиллагаанаас	Техникийн саатлаас	Цаг агаарын нөхцөлөөс	Гаднын байгууллагын буруутай ажиллагаанаас	Цахилгааны саатлаас		

### Хоёр. Талуудын харилцан холбоо барих мэргэжилтнүүдийн мэдээлэл

#### “МОНГОЛСАТ НЕТВОРКС” ХХК-ний зүгээс:

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:	DTH ашиглалтын ахлах инженер Б.Бямбанайдан Утас: 99067608. byambanaidan@mongolsat.mn
2.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:	Санхүүгийн албаны захирал Ч.Доржпагам Утас: 99948945. dorjpagam@mongolsat.mn



3.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:	Маркетингийн захирал А.Ариунаа Утас: 88118446. ariunaa@mongolsat.mn
4.	Гэрээ болон контентын асуудал гарсан үед:	Ерөнхий менежер М.Оюунцэцэг Утас: 9908 1038. info@mongolsat.mn

**ТВ сувгийн зүгээс:**

1.	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:	Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....
2.	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:	Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....
3.	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:	Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....
4.	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:	Нэр ..... /албан тушаал, утас:, И-мэйл хаяг: .....

Тайлбар:

Гэмтэл, сааталтай холбоотой тусгай журамлал: Аль нэг талд техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл талуудын инженерүүд бие биетэйгээ түргэн, шуурхай холбогдож, хамтран ажиллаж, тухайн асуудлыг шийдвэрлэхийг эрхэмлэнэ. ТВ сувгийн зүгээс техниктэй холбоотой ямар нэг гэмтэл, саатал, асуудал гарсны улмаас цацалт доголдож улмаар хэрэглэгч, үзэгчдийн зүгээс гомдол, санал гаргах, цацалтын үйлчилгээ, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа нөхцөл байдал олон нийт, нийгмийн сэтгэл зүйд үүсэх, эсхүл ийм нөхцөл байдал хэдийн үүссэн байдаг тул ТВ сувгийн зүгээс дээрх хүснэгтэд нэр дурдсан эсэхээс үл хамааран тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага зэрэгтэй холбоо барин шаардлагатай инженер, техникийн ажилтантай холбож өгөх талаар санал болгох эрхтэй. Тухайн телевизийн холбогдох албан тушаалтан, шууд удирдлага нь энэхүү санал, хүсэлтийг хүлээн авч, найрсаг, түргэн шуурхайгаар зохицуулж өгөх арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

Гүйцэтгэх захирал: .....

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: 99081038

Цахим хаяг: info@mongolsat.mn

Ерөнхий менежер: М.Оюунцэцэг

Гар утасны дугаар: 99081038

Цахим хаяг: info@mongolsat.mn

Гүйцэтгэх захирал:

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: \_\_\_\_\_

Цахим хаяг: \_\_\_\_\_

## ТӨЛБӨР ТООЦООНЫ ТУХАЙ

### 2. Сар бүрийн суваг дамжуулалтын төлбөр

№	Зардлын нэр төрөл	Холболтын төрөл	Суваг дамжуулалтын төлбөр ₮	
			УБ хот	Орон нутаг
1	1 Mbps IP урсгал түрээс	IP	....₮	....₮
2	Шилэн кабелийн түрээс	SDI	....₮	....₮

Жич: Дээрх бүх төлбөр НӨАТ ороогүй болно.

#### Тайлбар:

- “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.9-д зааснаар дээрх төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй байх зарчмыг баримтална.
- SD сувгийн хувьд хамгийн багадаа 2Mbps, HD сувгийн хувьд хамгийн багадаа 4Mbps урсгал шаардлагатай.
- Сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг нь Монголсат Нэтворкс ХХК-н төхөөрөмжийн өрөөнд бол шилэн кабелийн болон урсгал түрээсийн төлбөр 0₮ байна.

### ХАВСРАЛТ БАТАЛСАН:

Гүйцэтгэх захирал: .....

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: .....

Цахим хаяг: .....

Ерөнхий нягтлан бодогч: Ч.Доржпагам

Гар утасны дугаар: 99948945

Цахим хаяг: dorjpagam@mongolsat.mn

Гүйцэтгэх захирал:

\_\_\_\_\_ /гарын үсэг/

Гар утасны дугаар: \_\_\_\_\_

Цахим хаяг: \_\_\_\_\_

**ХӨТӨЛБӨР ИЛГЭЭХ ТУХАЙ**

1. Хөтөлбөрийн нэрийг монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй зөв бичсэн байх.
2. Монгол хэлний зөв бичгийн дүрэм, монгол хэлний найруулга зүй, өгүүлбэрийн бүтцийн тогтсон дэгийг мөрдөх.
3. Хөтөлбөрийн нэрний эхний үгийн эхний үсэг том үсгээр бусад үсэг жижиг үсгээр бичсэн байх.
4. Хөтөлбөрийн нэрний үг хооронд 1 мөрний зай авах.
5. Өдөр бүрийн эфирийн төгсгөлд заавал "Эфир завсарлага, Эфир хаасан" эсвэл "Эфир завсарласан" гэж хөтөлбөрийг төгсгөх.
6. Он сар өдөр (YYYY-MM-DD), цагийн формат (hh:mm) форматын дагуу байх.
7. Гадаад нэршлийг монгол хэлэнд орчуулсан байх.
8. Товчилсон үг нэршил ашиглахгүй нэрийг бүтнээр бичсэн байх.
9. Хөтөлбөрийг Excel формат дээр бэлдсэн байх.
10. Хөтөлбөрийн нэрийг 30 тэмдэгтэд багтаан бичих.

Жишээ:

Он сар өдөр	Цаг	Хөтөлбөрийн нэр
2024-00 00	6:00	....

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

**Гүйцэтгэх захирал:** Н.Бумчин

\_\_\_\_\_ /гарын үсэг/

**Гар утасны дугаар:** 99081038

**Цахим хаяг:** info@mongolsat.mn

**Ерөнхий менежер:** М.Оюунцэцэг

**Гар утасны дугаар:** 99081038

**Цахим хаяг:** info@mongolsat.mn

**Гүйцэтгэх захирал:**

\_\_\_\_\_ /гарын үсэг/

**Гар утасны дугаар:** \_\_\_\_\_

**Цахим хаяг:** \_\_\_\_\_